

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/159-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ж.Цогт Утас: 7036-3036 Цахим хаяг: Tsogtj@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12-13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-14
4. Аудитын тайлан	14-17
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15-16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХАСХОМ	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СОЁЛ,
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА
С.БААСАНЖАРГАЛ ТАНАА

2024.02.19 № СЭА-2024/159-НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус газар нь 69,394.3 мянган төгрөгийн хөрөнгийг *Иж бүрэн гэр, тавилга, хөгжим, тоног төхөөрөмж*-ийг аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас санхүүгийн үр дүнгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дүн өссөн байна.

Аудитын гол асуудал

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд оны эцэст буюу 12 дугаар сарын 24-ний өдөр Соёлын яамнаас 14,280.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас 14,210.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон нь зарлагын гүйлгээг хийх боломжгүй байдалд хүргэж, санхүүгийн тайланд өр, авлага үүсэх нөхцөл болсон байна.

Байгууллагын 2 албан хаагчийн жилийн эцсийн ХАСХОМ-ийг хянаж, баталгаажуулж байгаа эрх бүхий албан тушаалтанд сар бүр үндсэн цалингийн 40.0 хувиар нэмэгдэл тооцож, нийт 2,968.1 мянган төгрөг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,200,665.00	42,888,141.70
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	40,589.00	5,587.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	40,589.00	5,587.00
31210	Төгрөг	40,589.00	5,587.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	40,589.00	5,587.00
33	АВЛАГА	290,000.00	28,684,678.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	290,000.00	194,678.70
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	28,490,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,870,076.00	14,197,876.00
35400	Хангамжийн материал	9,870,076.00	14,197,876.00
35410	Бичиг хэргийн материал	1,380,300.00	954,700.00
35420	Аж ахуйн материал	5,442,600.00	7,036,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,047,176.00	6,207,176.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	47,615,088.55	103,996,004.79
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	47,615,088.55	103,996,004.79
39200	Биет хөрөнгө	46,115,088.55	102,796,004.79
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	29,787,600.00	36,500,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,491,570.07)	(10,232,262.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,911,301.00	39,841,301.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(92,242.38)	(3,653,121.71)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	42,838,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,498,912.50)
39300	Биет бус хөрөнгө	1,500,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(300,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	57,815,753.55	146,884,146.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,141,471.06	28,490,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,141,471.06	28,490,000.00
41300	Өглөг	2,141,471.06	28,490,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	747,211.06	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,394,260.00	28,490,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	55,674,282.49	118,394,146.49
51	Засгийн газрын хувь оролцоо	55,674,282.49	118,394,146.49
51200	Хуримтлагдсан үр дүн	55,674,282.49	118,394,146.49
51210	Өмнөх үеийн үр дүн	-	55,674,282.49
51220	Тайлант үеийн үр дүн	55,674,282.49	62,719,864.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	57,815,753.55	146,884,146.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	323,123,501.00	383,423,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,667,301.00	69,481,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,667,301.00	69,481,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,667,301.00	69,481,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	313,456,200.00	313,942,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	211,641,600.00	262,652,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	211,641,600.00	262,652,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,814,600.00	51,290,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,214,600.00	14,210,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,600,000.00	37,080,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	267,449,218.51	320,703,936.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	267,449,218.51	320,703,936.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,603,071.70	262,985,855.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,825,151.13	136,756,499.87
210101	Үндсэн цалин	84,458,175.47	83,749,738.79
210102	Нэмэгдэл	10,081,498.66	27,231,398.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,650,000.00	22,553,000.00
210104	Урамшуулал	3,635,477.00	3,222,362.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,963,155.12	17,039,393.44
210201	Тэтгэврийн даатгал	9,557,702.12	11,637,268.37
210202	Тэтгэмжийн даатгал	1,108,047.56	1,369,264.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	886,438.01	1,095,411.56
210204	Ажилгүйдлийн даатгал	194,872.29	264,351.49
210205	Эрүүл мэндийн даатгал	2,216,095.14	2,673,097.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,144,200.00	39,902,400.00
210301	Гэрэл, цахилгаан	653,932.00	1,210,287.77
210302	Түлш, халаалт	8,542,268.00	36,751,128.43
210303	Цэвэр, бохир ус	948,000.00	1,940,983.80
2104	Хангамж, бараа материалын зардал	33,879,429.00	6,950,906.00
210401	Бичиг хэрэг	738,810.00	1,104,450.00
210402	Тээвэр, шатахуун	10,877,627.00	2,330,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	453,592.00	884,356.00
210404	Ном, хэвлэл	20,500,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,309,400.00	2,631,900.00
2105	Нормативт зардал	3,991,000.00	508,270.00
210502	Хоол, хүнс	3,991,000.00	508,270.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,833,400.00	18,877,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,613,400.00	18,877,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,966,736.45	42,951,385.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,382,924.00	29,850,902.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,583,812.45	13,100,483.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,846,146.81	57,718,080.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,386,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,386,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,460,146.81	57,418,080.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,847,262.81	57,418,080.93
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,612,884.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	55,674,282.49	62,719,864.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	55,674,282.49	62,719,864.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	313,456,200.00	313,942,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	313,456,200.00	313,942,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	211,641,600.00	262,652,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	211,641,600.00	262,652,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	101,814,600.00	51,290,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62,214,600.00	14,210,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,600,000.00	37,080,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	303,456,011.00	313,977,402.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	303,456,011.00	313,977,402.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	239,609,864.19	227,769,321.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	109,161,248.09	137,285,770.03
210101	Үндсэн цалин	84,594,220.00	85,231,055.08
210102	Нэмэгдэл	9,461,551.09	26,705,855.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,470,000.00	22,239,621.92
210104	Урамшуулал	3,635,477.00	3,109,237.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,169,847.10	17,162,013.04
210201	Тэтгэврийн даатгал	9,764,394.10	11,621,400.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,108,047.56	1,529,057.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	886,438.01	1,099,672.70
210204	Ажилгүйдлийн даатгал	194,872.29	264,351.48
210205	Эрүүл мэндийн даатгал	2,216,095.14	2,647,530.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,144,200.00	39,902,400.00
210301	Гэрэл, цахилгаан	653,932.00	1,210,287.77
210302	Түлш, халаалт	8,542,268.00	36,751,128.43
210303	Цэвэр, бохир ус	948,000.00	1,940,983.80
2104	Хангамж, бараа материалын зардал	34,700,158.00	6,187,966.00
210401	Бичиг хэрэг	898,800.00	1,879,660.00
210402	Тээвэр, шатахуун	8,106,716.00	2,295,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	453,592.00	884,356.00
210404	Ном, хэвлэл	20,500,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,741,050.00	1,088,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,270,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,270,000.00	-
210602	Тавилга	16,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	-
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,333,400.00	25,327,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,113,400.00	25,327,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,831,011.00	1,904,172.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,831,011.00	1,904,172.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,846,146.81	86,208,080.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,386,000.00	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,386,000.00	300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	62,460,146.81	85,908,080.93
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	51,847,262.81	57,418,080.93
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,612,884.00	28,490,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,000,189.00	(35,002.00)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	9,959,600.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,959,600.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	9,959,600.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,959,600.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(9,959,600.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	40,589.00	(35,002.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	40,589.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,589.00	5,587.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	55,674,282.49	55,674,282.49
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	55,674,282.49	55,674,282.49
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	55,674,282.49	55,674,282.49
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	55,674,282.49	55,674,282.49
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	62,614,530.72	62,614,530.72
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	-	-	118,288,813.21	118,288,813.21

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	262,684,300.00	205,234,319.07	(57,449,980.93)	78.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,684,300.00	205,234,319.07	(57,449,980.93)	78.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,305,900.00	204,934,319.07	(57,371,580.93)	78.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,322,700.00	137,285,770.03	(50,036,929.97)	73.3
210101	Үндсэн цалин	112,966,600.00	85,231,055.08	(27,735,544.92)	75.4
210102	Нэмэгдэл	49,797,000.00	26,705,855.57	(23,091,144.43)	53.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,064,000.00	22,239,621.92	2,175,621.92	110.8
210104	Урамшуулал	4,495,100.00	3,109,237.46	(1,385,862.54)	69.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,415,400.00	17,162,013.04	(6,253,386.96)	73.3
210201	Тэтгэврийн даатгал	15,922,500.00	11,621,400.71	(4,301,099.29)	73.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,873,200.00	1,529,057.40	(344,142.60)	81.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,498,600.00	1,099,672.70	(398,927.30)	73.4
210204	Ажилгүйдлийн даатгал	374,600.00	264,351.48	(110,248.52)	70.6
210205	Эрүүл мэндийн даатгал	3,746,500.00	2,647,530.75	(1,098,969.25)	70.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,902,500.00	39,902,400.00	(100.00)	100.0
210301	Гэрэл, цахилгаан	1,202,400.00	1,210,287.77	7,887.77	100.7
210302	Түлш, халаалт	37,171,300.00	36,751,128.43	(420,171.57)	98.9
210303	Цэвэр, бохир ус	1,528,800.00	1,940,983.80	412,183.80	127.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,231,300.00	4,187,966.00	(43,334.00)	99.0
210401	Бичиг хэрэг	1,137,700.00	1,879,660.00	741,960.00	165.2
210402	Тээвэр, шатахуун	590,100.00	295,200.00	(294,900.00)	50.0
210403	Цуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,314,700.00	884,356.00	(430,344.00)	67.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,800.00	40,000.00	(30,800.00)	56.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,118,000.00	1,088,750.00	(29,250.00)	97.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,467,000.00	5,467,000.00		- 100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,467,000.00	5,467,000.00		- 100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,967,000.00	929,170.00	(1,037,830.00)	47.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,967,000.00	929,170.00	(1,037,830.00)	47.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	378,400.00	300,000.00	(78,400.00)	79.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	378,400.00	300,000.00	(78,400.00)	79.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	378,400.00	300,000.00	(78,400.00)	79.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	262,684,300.00	205,234,319.07	(57,449,980.93)	78.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	262,684,300.00	205,234,319.07	(57,449,980.93)	78.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	262,684,300.00	205,234,319.07	(57,449,980.93)	78.1
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1.00	1.00		- 100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00		- 100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00		- 100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11.00	7.00	(4.00)	63.6
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		- 100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8.00	4.00	(4.00)	50.0
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00		- 100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	11.00	11.00		- 100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	5.00	(4.00)	55.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	51,325,022.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,325,022.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,325,022.00
210402	Тээвэр, шатахуун	2,035,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19,860,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	940,002.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,490,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	28,490,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	79,815,002.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40,589.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,587.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газар нь “Орон нутгийн түвшинд үндэсний бахархал, эх хэл, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, эх оронч, оюунлаг, бүтээлч монгол хүнийг хөгжүүлнэ.” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Соёлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д аймгийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёл, урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Соёлын байгууллагын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу төрөөс санхүүжүүлэх, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авах,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийн соёлын байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих,
- Соёлын статистик мэдээлэл, соёлын байгууллагын тайланг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант онд тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Соёл, урлагийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88,963.1 мянган төгрөгөөр буюу 2.5 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	40.6	5.6	(35.0)
Авлага	-	28,684.7	28,684.7
Урьдчилгаа	290.0	-	(290.0)
Бараа материал	9,870.1	14,197.9	4,327.8
Үндсэн хөрөнгө	47,615.1	103,996.0	56,380.9
Нийт хөрөнгө	57,815.7	146,884.1	89,068.4
Өр төлбөр	2,141.5	28,490.0	26,348.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	55,674.3	118,394.1	65,719.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	57,815.7	146,884.1	89,068.4

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлага данс нь 28,684.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь оны эцэст тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Соёлын яамнаас 14,280.0 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас 14,210.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг төсөвт татан төвлөрүүлсэн,

- Бараа материал дансны үлдэгдэл 14,197.9 мянган төгрөг болж 4,327.8 мянган төгрөгөөр өссөн нь 8,902.6 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 103,996.0 мянган төгрөг болж 56,380.9 мянган төгрөгөөр өссөн нь 42,838.5 мянган төгрөгийн иж бүрэн гэр, 19,842.9 мянган төгрөгийн тавилга, 6,712.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас тус тус шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газар нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 301,234.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлсийг 20,081.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 7,297.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,497.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 8,672.5 мянган төгрөгөөр зэрэг нийт 38,549.7 мянган төгрөгөөр бууруулан, 262,684.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 262,684.3 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 205,234.3 мянган төгрөг буюу 78.1 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын зардлыг 56,290.3 мянган төгрөгөөр хэмнэж, 57,450.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	254,712.1	204,266.0	50,446.1	80.2
2	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ /80103/	7,593.8	668.3	6,925.5	8.8
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг /80802/	378.4	300.0	78.4	79.3
	Нийт	262,684.3	205,234.3	57,450.0	78.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд нийт **51,290.0** мянган төгрөгийн орлого төвлөрснөөс 22,800.0 мянган төгрөгийг “Нүүдэлчин монгол” соёлын биет бус өвийн их наадамд зарцуулж, 28,490.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Цогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 267,449.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,674.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Гар утасны зардал гаргаагүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4 дэх “... байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчиж 1,377.0 мянган төгрөгийн видео нэвтрүүлэг хийлгэсэн зөрчил илэрлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансанд мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллээс 45 мэдээллийг огт мэдээлээгүй ба 1 мэдээллийг хугацаа хоцроож, 9 мэдээллийг буруу мэдээлсэн байна. Үүнд:

1. Огт мэдээлээгүй:

- Хагас жилийн санхүүгийн тайлан,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл -11 удаа
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр -11 удаа,
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт -11 удаа,
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн -11 удаа,

2. Хоцроож мэдээлсэн:

- *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан*
3. Буруу мэдээлсэн:
- *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал -5 удаа*
 - *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт – 4 удаа*

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус төвийн үйл ажиллагаанд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус ангийн 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 19,818.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс томилолтын зардал илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоон, авлага, өр төлбөр үүсгэсэн, төсвийг үр ашиггүй зарцуулсан, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ гүйцэтгэсэн зэрэг 4 зөрчилд албан шаардлага хүргүүлж, худалдан авалтыг баримтаар баталгаажуулаагүй, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон, санхүүгийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийгээгүй зөрчлүүдэд 3 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 87.5 хувийн биелэлттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	157.0	1	157.0	100
Албан шаардлага	1	2,431.4	1	2,431.4	100
	1	6,990.0	1	6,990.0	100
	2	5,500.0	2	5,500.0	100
Зөвлөмж	1	4,739.7	1	4,739.7	100
	1	-	-	-	-
	1	-	1	-	100
Нийт дүн	8	19,818.1	4	19,818.1	87.5

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **15,527.8** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 682.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,045.3 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 12,800.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Тус газрын нягтлан бодогч П.Мөнхтуяа, үйлчлэгч С.Мөнгөнцэцэг нарт *Төрийн үйлчилгээний албан хаагч / орон нутагт ажилласны нэмэгдэл нийт 682.5 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалт болон Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 3, 4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.*

1.2 Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалингийн нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. *“Нүүдэлчин монгол” өв соёлын наадмын баримтат нэвтрүүлэгт 1,377.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.4: “... байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.*

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний хөтөлбөр, арга хэмжээний зардлаас байгууллагаас төлөх НДШ-д 511.3 мянган төгрөг, төрийн аудитын байгууллагаас тавьсан төлбөрийн актыг барагдуулахад 157.0 мянган төгрөг зэрэг нийт **668.3** мянган төгрөгийг хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: “Нүүдэлчин монгол” өв соёлын наадмын үйл ажиллагаанд оролцогчдын байрны төлбөрт бүрдэл дутуу анхан шатны баримтаар “Дүүчин” ХХК-д **12,800.0** мянган төгрөг шилжүүлж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дэх “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2 Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэмэгдэл илүү тооцож олгосон	1	682.5	1	682.5								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн	1	1,377.0			1	1,377.0						
Хөтөлбөр хооронд гүйлгэн зарцуулсан	1	668.3			1	668.3						
Бүрдэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	12,800.0					1	12,800.0				
Дүн	4	15,527.8	1	682.5	2	2,045.3	1	12,800.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1	-			1	-		
Огт мэдээлээгүй	45	-			45	-		
Буруу мэдээлсэн	9	-			9	-		
Нийт дүн	55	-			55	-		